

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсныг
дэмжин баталгаажуулах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20, 8.11.26 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк болон “Аурум Металс” ХХК нарын хооронд байгуулагдсан дараах хэлцлүүдийг хүлээн зөвшөөрч, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг удирдлага болгон хүчин төгөлдөр байдлыг дэмжин баталгаажуулсугай.

- 1.1. 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй, ЗГ/СС240202011-3-1 дугаартай “Зээлийн нэмэлт гэрээ”;
- 1.2. 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй, Б/СС241210011-3 дугаартай “Эх үүсвэргүй аккредитив нээх, баталгаа гаргах гэрээ”, ЗГ/СС241210011-3 дугаартай “Зээлийн гэрээ”, ЗБ/СС241210011-3-7 дугаартай “Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ”;
- 1.3. 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулагдсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй, ЗЭНГ/СС250509020-2 дугаартай “Зээлийн эрх нээх гэрээ”, Б/СС250509020-2 дугаартай “Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх гэрээ”, ЗБ/СС250509020-2-6 дугаартай “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ”, ЗБ/СС250509020-2-3 дугаартай “Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ”;
- 1.4. 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр байгуулагдсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй, ЗЭНГ/СС250509020-2-1 дугаартай “Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ”, ЗБ/СС250509020-2-6-1 дугаартай “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээ”, ТЗБ/СС250610022-2-1 дугаартай “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл барьцаалах гэрээ”.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГАНДОЛФ КОПША